

Николас, Елена хоёрын түүх

Николас, Елена хоёр гэрлээд 10 жил болж байгаа ба гурван хүүхэдтэй. Тэд хоёул гэр бүлээ Есүс Христ болон Түүний сайн мэдээний суурин дээр байгуулахыг хүсдэг ба тэнгэрлэгээр томилогдсон гэр бүлийн үүрэг хариуцлагаа биелүүлэхийг хичээдэг.

Бусад гэрлэсэн хосын нэгэн адил Николас, Елена хоёрын дунд үл ойлголцол гардаг. Тэд ихэвчлэн мөнгөнөөс болж санал зөрөлддөг. Николас бүтэн цагаар гадуур ажилладаг. Елена хүүхдүүдээ асарч, гэр орондоо бүтэн анхаарал хандуулахын хажуугаар хааяа нэмэлт ажил хийдэг. Николас гэр орноо тэргүүлэх үүрэгтэйгээс гадна арай их мөнгө олдог учраас мөнгө хэрхэн зарцуулж байгаа талаар үг хэлэх эрхтэй гэж өөрийгөө үздэг. Елена Николасаас илүү хүүхдүүдтэйгээ хамт цагийг өнгөрүүлдэг тул тэдэнтэй холбоотой шийдвэр гаргахдаа давуу эрх эдэлнэ гэж өөрийгөө боддог. Тэр өнгөрсөн хугацаанд заримдаа Николас т хэлэлгүйгээр мөнгөө хүссэнээрээ зарцуулдаг байсан.

Николас, Елена хоёр саяхан хадгалсан мөнгөөрөө юу хийх талаар ярилцсан. Николас өөрөө ажилдаа явах мөн гэр бүлийнхнээ аваад ийш тийш явахад хялбар болгох үүднээс автомашин худалдаж авахыг хүсжээ. Елена хүүхдүүдээ аваад хамаатнууд дээрээ очиж, тэднийг томрохоос өмнө хамтдаа зугаатай дурсамж, туршлага бүтээхийг хүссэн.

Николас, Елена хоёрын санал зөрөлдөөн тэдэнд хүндээр тусаж байсан ч тэд шийдвэр гаргах ёстой байв.

- Николас, Елена хоёрт энэ мөнгөөр юу хийхээ шийдэхэд тулгарч буй хамгийн том ямар бэрхшээл байна гэж та хэлэх вэ?
- Тэд гэр бүлийнхээ төлөө шийдвэр гаргахдаа эрх тэгш болон тэргүүлэх оролцооны талаар юуг илүү сайн ойлгох хэрэгтэй гэж та бодож байна вэ? (Бэлтгэх материалын 3-р хэсгийг үзнэ үү.)
- Хэрэв та Николас эсвэл Елена байсан бол энэ шийдвэрийнхээ талаар хань ижилтэйгээ Христийн адилаар хэрхэн зөвлөлдөх вэ?